

# ДОТООДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ



2025.06.16



## Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

### ТОВЧ

- Монголбанкны бодлогын хүү 12%-д хэвээр үлдэв.
- Өр-орлогын хязгаар 50% боллоо.
- Инфляц 2026 онд 10%-д хүрэх төлөвтэй.
- Мандал Даатгал 31.2 сая хувьцаа халааслана.
- Үнэт цаасны арилжаа өмнөх оны мөн үеэс 89% өсөв.

### МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-1.45%	1.35%	25.47%
MSE A	-1.63%	0.05%	20.27%
MSE B	0.08%	-0.07%	34.89%
2025/06/09 – 2025/06/13			

### Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
MNDL	3,951,434,443.09
INV	1,047,661,170.00
KHAN	417,494,913.00
ERDN	322,046,874.00
AARD	252,882,806.00
2025/06/09 – 2025/06/13	

### Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
HVL	180.25	23.26%
AOI	1,748.00	15.00%
HSX	7,290.00	14.98%
BEU	879.00	14.90%
UID	3,500.00	12.90%
2025/06/09 – 2025/06/13		

2025 он 06-р сарын 16

Зах зээлийн  
үнэлгээ тэрбум ₮

**12,016**

ТОП-20 индекс

**48,452**

MSE A

**17,550**

MSE B

**14,325**



### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

**2.4%**

2024 - I улирал

Инфляц

**8.3%**

2025-05 сар

ГВУН(сая\$)

**5,193.73**

2025-05 сар

Бодлогын  
хүү

**12.0%**

ЗГ-ын бондын  
өгөөж

**6.6%**

USD/MNT

**3,576.53**

2025-06-15



## Эдийн засгийн мэдээлэл

### МОНГОЛБАНК БОДЛОГЫН ХҮҮГ 12%-Д ХЭВЭЭР ХАДГАЛЛАА



Монголбанкнаас 2025 оны 6-р сарын 12, 13-нд зохион байгуулсан Мөнгөний бодлогын хорооны ээлжит хуралдаанаар эдийн засаг, банк санхүүгийн орчин, гадаад дотоод эрсдэл, зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан дараах хоёр чухал шийдвэрийг гаргалаа:

- Бодлогын хүүг хэвээр хадгалав

Бодлогын хүүг 12 хувь дээр хадгалах шийдвэр гаргасан нь инфляцын саарсан ч тодорхойгүй байдал бүрэн арилж амжаагүйг илтгэж байна. Хүүг тогтвортой байлгаснаар зах зээлийн хүлээлт, санхүүгийн нөхцөл байдлыг тэнцвэржүүлэх зорилготой гэж үзэж болно.

- Хэрэглээний зээлийн зохицуулалтыг чангатгав

Шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчилсөн тэтгэвэр, тэтгэмжийн орлогоор барьцаалсан зээлд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 50 хувь болгож тогтоолоо. Энэ нь хэрэглээний зээлийн эрсдэлийг хянаж, зээлийн хэт тэлэлтээс сэргийлэх зорилготой шийдвэр юм.

Монголбанк эдийн засгийн эрсдэлтэй орчинд бодлогын уян хатан, хянуур байдлыг хадгалж байна. Инфляц тодорхой хэмжээнд саарсан ч тогтворжилт бүрэн хангагдаагүй, эдийн засгийн өсөлт сэргэлтийн эхэн шатандаа байна. Ирэх улирлуудад төсвийн бодлого, экспортын гүйцэтгэл, валютын ханш эдийн засгийн чиглэлийг тодорхойлох гол хүчин зүйл байх болно.

### ШИНЖЭЭЧИД 2026 ОНД ИНФЛЯЦ 10%-Д ХАДГАЛАГДАНА ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА



2025 оны II улирлын судалгаагаар инфляц 9.8%, эдийн засгийн өсөлт 4.0%, бодлогын хүү 12.0%, зээлийн хүү 17.2% байхаар таамаглагдаж байна. 2026 оны I улиралд инфляц 10.0%-д хүрч, эдийн засгийн өсөлт 4.6%-д өсөх төлөвтэй байна. Бодлогын хүү бага зэрэг буурч 11.6%-д хүрэх хүлээлттэй. Инфляц өндөр хэвээр үргэлжилж байгаа ч эдийн засгийн өсөлт сайжрах, мөнгөний бодлого аажмаар зөөлрөх боломжтойг харуулж байна. Энэ нь макро эдийн засгийн орчин тогтвортой сэргэх хандлагатай байгааг илтгэнэ.

Хүснэгт 1. Эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн хүлээлт

Үзүүлэлт	2025 оны II улирал	2026 оны I улирал
Инфляц	9.8%	10.0%
Эдийн засгийн өсөлт	4.0%	4.6%
Бодлогын хүү	12.0%	11.6%
Зээлийн хүү	17.2%	17.3%



## Зах зээлийн мэдээлэл

### МАНДАЛ ДААТГАЛ 5%-ИЙН ХУВЬЦААГАА ЭРГҮҮЛЭН АВНА

Мандал даатгал ХК (MSE: MNDL) компани 31.2 сая ширхэг буюу нийт хувьцааны 5%-тай тэнцэх хэмжээг эргүүлэн худалдан авч, халааслах шийдвэр гаргалаа. Худалдан авах ажиллагаа 6 сарын 26 хүртэл багцаар болон зах зээлээс явагдах юм.

Компанийн хувьцааны эзэмшлийг харахад 80.86%-ийг томоохон 4 хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бол үлдсэн 19.14%-ийг 14,400 гаруй жижиг хөрөнгө оруулагчид эзэмшдэг. Өдрийн дундаж арилжаа 2024 онд 6.8 сая төгрөгтэй буюу идэвхи сул байгаа нь анхаарал татна.

Хүснэгт 2. ТОП-20 индекс (оны эхнээс)


#### Компанийн хувьцааг халааслах нөхцөл

Өдөрт худалдан авах дээд хязгаар	31,215,080 ширхэг хүртэл
Эргүүлэн худалдан авах дээд үнэ	Эхний өдрийн хаалтын ханш +15%
Багц арилжааны дүнгийн хязгаар	250 сая төгрөгөөс дээш, өмнөх хаалтын ханш +5% хүртэл
Худалдан авах хугацаа	2025.06.16 – 2025.06.27
Мэдээлэл хүргэх	<a href="http://www.mandal.mn">www.mandal.mn</a> , <a href="http://www.mse.mn">www.mse.mn</a>

### ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИДЭВХИ ЭНЭ ОНД СЭРГЭЛТТЭЙ БАЙНА

2025 оны эхний дөрвөн сарын байдлаар үнэт цаасны зах зээлд нийт 260.1 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 25.8 тэрбум төгрөгөөр (11.0%) өссөн үзүүлэлт болж байна. Үүнээс анхдагч зах зээлийн арилжаа 68.0 тэрбум төгрөгөөр (26.2%), хоёрдогч зах зээлийн арилжаа 192.0 тэрбум төгрөгөөр (73.8%) тус тус бүрдүүлжээ.

График 1. ТОП-20 индекс (оны эхнээс)



Нийт гүйлгээний бүтцийг авч үзвэл:

- 41.5 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас,
- 26.8 хувийг компанийн бонд,
- 23.9 хувийг компанийн хувьцаа,
- 7.4 хувийг Засгийн газрын бонд,
- 0.3 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх тус тус эзэлж байна.

Түүнчлэн, зөвхөн 2025 оны 4 дүгээр сард үнэт цаасны арилжаа 87.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 41.2 тэрбум төгрөгөөр (89.0%), өмнөх сараас 23.0 тэрбум төгрөгөөр (35.6%) тус тус өссөн нь зах зээл идэвхжиж буйг илтгэж байна.




## ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

### Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.